

**БАТЛАВ**  
УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗРЫН ДАРГА



Ц.ТӨРХҮҮ

**УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗАР**

**АГААРЖУУЛАЛТЫН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ  
АВАХ ҮНИЙН САНАЛЫН БАРИМТ БИЧИГ**

**Төслийн нэр:** Давтамж хувиргагчийн өрөөнд агааржуулалтын тоног төхөөрөмж нийлүүлэгчийг сонгон шалгаруулах

**Тендер шалгаруулалт/  
гэрээний дугаар:** УСУГ-ХА-2020-94

УЛААНБААТАР ХОТ

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо: 2020.04.30

*Ус сувгийн удирдах газар* нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос *агааржуулалтын тоног төхөөрөмж*-ийг нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал шалгаруулалтын нэр: **Давтамж хувиргагчийн өрөөнд агааржуулалтын тоног төхөөрөмж нийлүүлэгчийг сонгон шалгаруулах.**

Үнийн санал шалгаруулалтын дугаар: **УСУГ-ХА-2020-94**

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2020 оны 5 дугаар сарын 7-ны өдрийн 09 цаг 00 минутаас өмнө** Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем /[www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)/ хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020 оны 5 дугаар сарын 7-ны өдрийн 09 цаг 30 минут**-д нээнэ.

Цахим тендер зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж **50,000.00 /гавин мянган/** төгрөгийг [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) – ээр банкны цахим төлбөр тооцооны системийг ашиглан төлнө.

Дотоодын давуу эрх: *Тооцохгүй.*

Гадаадын этгээд оролцох эрхгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 3-р хороо, Ус Сувгийн Удирдах Газар, Токиогийн гудамж-5, өөрийн байр, Р.Батсүрэн Утас: 70157018-121.**

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.

2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

  - (а) Үнийн санал;
  - (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
  - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
  - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
  - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тогтмол үнэ**

4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**

5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.

5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**

6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байна.

- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Дараах баримт бичгийг ирүүлэх:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Сүүлийн 2 жилд буюу 2018, 2019 онуудын аль нэг онд ижил төстэй ажил /ижил төстэй гэдэгт зөвхөн агаар сэлгэлт, хангамжийн ажлыг ойлгоно/ гүйцэтгэсэн тухай мэдээлэл ирүүлэх. Үүнд: гэрээний хуулбар, ажил хүлээлгэн өгсөн акт /эсвэл гэрээ дүгнэсэн протокол/, тухайн гэрээний үнийн дүн бүхий и-баримтын “илгээгдсэн” төлбөрийн баримт ба падааны хуулбарыг ирүүлэх, “нэхэмжлэх”-ийн хуулбар ирүүлэхийг тооцохгүйг анхаарна уу!/.</li> <li>2. Сүүлийн 2 жил /2018, 2019 он/-ийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлангийн ирүүлэх.</li> <li>3. 2018, 2019 он тус бүрийн борлуулалтын орлого нь манай төсөвт өртгөөс дээш байх.</li> <li>4. 2018, 2019 он тус бүрт ашигтай ажилласан байх.</li> <li>5. Тендерт оролцогч нь хэрэгжүүлж байгаа болон хэрэгжүүлэх эрх авсан гэрээ байгаа эсэхийг албан бичгээр ирүүлэх.</li> <li>6. Захиалагчаас дээрх хэрэгжүүлж буй гэрээний талаар тодорхойлолт, мэдээлэл авахад татгалзах зүйлгүй гэсэн мэдэгдлийг албан бичгээр ирүүлэх.</li> </ol> <p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд: <b>шаардлагагүй</b></p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> хаягаар өөрийн аж ахуйн нэгжийн тоон гарын үсэг ашиглан нэвтэрч цахим хэлбэр /PDF/-ээр илгээнэ. Цахим тендер зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж <b>50,000.00 /тавин мянган/</b> төгрөгийг <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> – ээр банкны цахим төлбөр тооцооны системийг ашиглан төлнө. Огноо: <b>2020 оны 5 дугаар сарын 7-ны өдөр.</b> Цаг: <b>09 цаг 00 минут</b></p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Байгууллагын хаяг: <b>Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 3-р хороо, Ус Сувгийн Удирдах Газар, Токиогийн гудамж-5 өөрийн байр</b> Давхар болон өрөөний дугаар: <b>Хоёр давхарт 201 тоот өрөө.</b> Огноо: <b>2020 оны 5 дугаар сарын 7-ны өдөр</b> Цаг: <b>09 цаг 30 минут</b></p>
ТӨӨЗ 2.3	<p>Дөрөвдүгээр бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Аж ахуй нэгжийн гэрчилгээний хуулбар,</li> <li>2. Харьяа дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолт ирүүлэх,</li> <li>3. Өгөгдсөн барааны нэр төрөл болон тоо хэмжээний дагуу гаргасан үнийн санал ирүүлэх,</li> <li>4. Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч бол гэрчилгээний хуулбар ирүүлэх,</li> <li>5. Нийлүүлэхээр санал болгож байгаа бараа нь захиалагчийн техникийн тодорхойлолт болон шаардлагад бүрэн нийцсэн байх,</li> <li>6. Нийлүүлэхээр санал болгож байгаа барааны талаарх дэлгэрэнгүй танилцуулга ирүүлэх /манай техникийн тодорхойлолтыг хуулбарлан ирүүлбэл тооцохгүй болохыг анхаарна уу/,</li> <li>7. Тухайн тоног төхөөрөмжийг манай заасан цэгт угсарч суурилуулан туршилт тохиргоо хийж хүлээлгэн өгөх тухай албан бичиг ирүүлэх,</li> <li>8. Санал болгож байгаа бараа нь манай техник үзүүлэлт болон тоо хэмжээнээс зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.</li> <li>9. Нийлүүлэхээр санал болгосон бараа болон ажилдаа 1 болон түүнээс дээш жилийн баталгаа өгөх, албан бичгээр ирүүлэх.</li> </ol>

10. Тендерийн баримт бичиг нь үнэн зөв, тодорхой гаргацтай байна. Унших боломжгүй, тодорхойгүйн улмаас үнэлгээ хийх боломжгүй нөхцөл байдал үүсэхээр бол үнэлгээний хороо нь уг тендерээс татгалзах үндэслэл болно.
11. Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна. Татварын тодорхойлолт ирүүлэх шаардлагагүй бөгөөд Татварын ерөнхий газрын цахим мэдээллийн сангаас тендерт оролцогчийн татварын өр, төлбөрийн талаарх мэдээллийг тендерийн нээлттэй хамт татаж шалгах тул өр, төлбөргүй байх шаардлагатай.
12. Харьяа дүүргийн татварын хэлтэс, Нийгмийн даатгал болон харилцагч банк, эрх бүхий бусад байгууллагаас тодруулга авахад татгалзах зүйлгүй гэсэн албан бичиг ирүүлэх,
13. Тендерт оролцогч нь сүүлийн 2 жилд нийгмийн хариуцлагын хүрээнд байгаль орчин, олон нийтийн эрүүл мэнд, сайн сайхны төлөө хийж хэрэгжүүлсэн ажил, төсөл арга хэмжээний тухай мэдээлэл ирүүлсэн бол давуу тал болно. /нотлох баримт болох тайлан, төлөвлөгөө, гэрээ, гүйцэтгэл гэх мэтийг нотариатаар батлуулан ирүүлнэ/.
14. 2019 оны аудитын өгсөн зөвлөмжийн дагуу тендерт оролцогч нь манай байгууллагын шийдвэр гаргах түвшиний албан тушаалтан, инженер техникийн ажилчтануудтай нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3.1.5, 3.1.6, 11.1-д заасан нөхцөл байдал үүсээгүй болохыг илэрхийлсэн албан бичиг ирүүлэх. Хэрэв дээрх нөхцөл байдал үүссэн тохиолдолд тухайн тендерээс татгалзах үндэслэл болно./Дээрх нөхцөл үүссэнийг нуун дарагдуулсан болон худал мэдүүлснээс гарах үр дагаврыг үнэлгээний хороо нь хариуцахгүй болно/

Дээр заасан материалуудын аль нэгийг ирүүлээгүй тохиолдолд уг тендерээс татгалзах үндэслэл болно.

Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна.

**Анхааруулга:**

- Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- УИХ-ын 2019.03.22-ны өдрийн чуулганы хуралдаанаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хууль 2019.06.01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөгдөх бөгөөд уг хуулийн 55 дугаар зүйлийн 55.9-д “Тендерт оролцогчдын гомдлыг үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд энэ хуулийн 20.7.3-т заасны дагуу тендерийн баталгааг улсын орлого болгох дээд хэмжээ 20 сая төгрөгөөс хэтрэхгүй. Гомдлыг үндэслэлтэй гэж шийдвэрлэсэн бол тендерийн баталгааг буцаан олгоно.” гэж заасан тул тендерт оролцогч тухайн төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичгийн шаардлагыг хангаж буй эсэх, нотлох баримтуудыг бүрэн гүйцэт бэлдсэн эсэхээ сайтар нягталж үзсэний үндсэн дээр тендер шалгаруулалтад оролцож байхыг хүсье. Учир нь тендер шалгаруулалтын үр дүнг үл зөвшөөрч Сангийн яаманд гаргасан гомдол “үндэслэлгүй” гэж шийдвэрлэгдсэн тохиолдолд тендерийн баталгааг

	улсын орлого болгох эрх зүйн зохицуулалт 2019.06.01-ний өдрөөс үйлчилж эхэлсэн болно.
<b>ТӨӨЗ 6.2</b>	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <i>багцгүй.</i>

Гурав. **ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

1. Барааны тодорхойлолт: Барааны техникийн тодорхойлолтыг хавсралтаас харна уу.
2. **Стандарт:** Тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно.
3. **Баглаа, боодол:** Барааны сав баглаа боодол нь шороо, тоосноос хамгаалсан битүүлжлэлтэй байх, барааг хүлээлгэн өгөхдөө бараа хүлээлцсэн баримт, тухайн барааны зарлагын баримт, төлбөрийн нэхэмжлэхийн хамт өгнө.
4. **Бараа хүргэх газар:** *Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 3-р хороо, Ус Сувгийн Удирдах Газар, Токиогийн гудамж-5 өөрийн байр.*
5. **Бараа нийлүүлэлтийн хуваарь:**

Д/д	Барааны нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэм. нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг (Ажлын талбай)	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
						Бараа нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Бараа нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа (Тендерт оролцогч энэ баганыг бөглөнө)
1	2		3	4	5	6	7	8
1	Агааржуулалтын тоног төхөөрөмж	Хавсралтаас харна уу.	1	ком	Ус сувгийн удирдах газрын Ус хангамжийн албаны Төвийн эх үүсвэрийн байр	2020.05.15	2020.06.01	

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

**1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:



## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхгүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |  |       |  |
|--|-------|--|
| 1. Шалгах болон турших                             | 1.1.  | Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.   |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1.  | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх                                | 3.1.  | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.  |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх     | 4.1.  | Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.  |
| 5. Баталгаат засварын хугацаа                      | 5.1.  | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа <b>[тоо]</b> жил байна.   |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах                        | 6.1.  | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.   |
| 7. Төлбөр  | 7.1.  | Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш <b>[ГТН-д заасан тоо]</b> хоногийн дотор шуурхай хийнэ.  |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь                         | 8.1.  | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.   |
| 9. Алданги оногдуулах                              | 9.1.  | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.  |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах         | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.  |
| 11. Маргааныг шийдвэрлэх                           | 11.1. | Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.   |

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- 1. Шалгах болон турших (ГЕН – 1)** 1.1. Захиалсан барааг Захиалагчийн заасан газарт нийлүүлэгч болон захиалагч талын төлөөлөл байлцуулан бүрэн, бүтэн эсэхийг шалгаж угсарч суурилуулан, туршилт тохируулга хийж хүлээлгэн өгнө.
- 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)** 2.1. Бараа нийлүүлэлт ба нийлүүлэгчийн бүрдүүлэх баримт бичгүүд:
- 1) Нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь, зарлагын падаан;
  - 2) Тухайн тоног төхөөрөмжийн гарын авлага болон зааварчилгаа;
  - 3) Үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалт туршилтын гэрчилгээ;
  - 4) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
- 3. Баталгаат засвар (ГЕН-5)** 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
- 4. Төлбөр (ГЕН – 7)** 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
1. Урьдчилгаа төлбөр олгохгүй,
  2. Гэрээний үнийн 95 хувьтай тэнцэх дүнг бараа нийлүүлснээс хойш 7-10 хоногийн дотор нэхэмжлэх болон захиалагчийн хүлээн авсан тухай актыг үндэслэн төлнө.
  3. Үлдэгдэл төлбөр болох 5 хувийг чанарын баталгааны хугацаа дууссаны дараа ашиглагч албаны мэдэгдэл болон гүйцэтгэгч байгууллагын нэхэмжлэх болон албан хүсэлтийг харгалзан төлнө.
- Гэрээний дагуу нийлүүлсэн барааг хүлээж авсан тухай акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
- 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)<sup>1</sup>** 9.1. Алданги оногдуулах хувь: *Гүйцэтгээгүй үүргийн хугацаа хэтэрсэн хоног тутамд 0,05 хувь.*
- Алдангийн нийт дүн: *гэрээний нийт үнийн дүнгийн 10 хувиас хэтрэхгүй байна.*

<sup>1</sup> Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ<sup>2</sup>

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ	НИЙЛҮҮЛЭГЧ
_____ (Тамга, тэмдэг)	_____ (Тамга, тэмдэг)
_____ (Гарын үсэг)	_____ (Гарын үсэг)
_____ (Албан тушаал)	_____ (Албан тушаал)

**[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_ сарын \_\_\_\_ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -наас \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>3</sup>;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

<sup>2</sup> Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

<sup>3</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]* \_\_\_\_\_

ТАМГА


*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]* \_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*


  
**БАТЛАВ**
  
 УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗАР
   
 ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР *М. Дагвацэрэн* /Ж.ДАГВАСҮРЭН/
   
**Техникийн тодорхойлолт**

<b>Төслийн нэр, хүчин чадал/</b> бараа материал худалдан авах, ажил үйлчилгээ, биет бус хөрөнгө, зөвлөх үйлчилгээ/	Давтамж хувиргагчийн байранд агааржуулалт хийх
<b>Төсөл хэрэгжих алба, хэлтэс</b>	УХА
<b>Төсөл хэрэгжих хугацаа</b>	2020 оны 2 дугаар улирал
<b>Үндсэн хөрөнгийн код</b>	
<b>Байршил</b>	Төвийн эх үүсвэр
<b>Хөрөнгийн ангилал</b> / бараа материал худалдан авалт, техник технологийн шинэчлэл, их ба урсгал засвар/	1.1.10 Техник технологийн шинэчлэл
<b>Огноо</b>	2019.12.23

**Зорилго 1.** Давтамж хувиргагчийн хэвийн найдвартай ажиллагааг хангах

**2. Бүрдэл:** Төвийн эх үүсвэрийн 6 кВ-ын давтамж хувиргагчийн байранд агааржуулалтын хоолой угсрах.

**3. Техникийн үзүүлэлт:** Өрөөний урт-3.5м, өргөн-4.5м, өндөр-4м, эзэлхүүн-63м<sup>3</sup> ба агаар сэлгэлтийг чөлөөтэй явуулахын тулд давтамж хувиргагчаас гарч буй халуун агаарыг сорж гадагшлуулах 7м урттай, 1мм-ийн зузаантай агааржуулалтын хоолой хийх. Агааржуулалтын хоолой дунд 1кВт-ын чадалтай, 220В-ын хүчдэлээр ажилладаг шугамын сорох сэнс байрлуулах.

**4. Чанарын шалгуур**  
Үйлдвэрлэгчийн гэрчилгээтэй, чанарын баталгаат хугацаа 12 сар байх.

**5. Бусад:** Нийлүүлэгч тал суурилуулж, туршилт тохируулга хийн хүлээлгэж өгөх.

БОЛОВСРУУЛСАН: АЛБАНЫ ДАРГА  
АЛБАНЫ ИНЖЕНЕР

/С.АМАРСАНАА/  
/Б.БАЯРБИЛЭГ/

ХЯНАСАН:  
ИБХ-ИЙН ДАРГА  
ХҮХ-ИЙН ДАРГА  
ИБХ-ИЙН ЦАХИЛГААН  
АВТОМАТИКИЙН ИНЖЕНЕР  
ХҮХ-ИЙН ИНЖЕНЕР

/Н.ОДХҮҮ/  
/Ж.НАСАНТОГТОХ/  
/Ж.БАТЖАРГАЛ/  
/Р.БАТСҮРЭН/